

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2013
өдөр**

оны

...

дугаар

сарын

Улаанбаатар хот

...-ны

ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГАТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь газар нутгийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авах, түүний хилийн цэс, орчны бүсийг тогтоох, тэдгээрийн хамгаалалтын дэглэмийг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагын бүрэн эрх, төрийн бус байгууллага, иргэн, хувийн хэвшлийн оролцоо, эрх, үүрэг, хариуцлага, тусгай хамгаалалттай газар нутгийн удирдлага, зохион байгуулалт, төлөвлөлт, санхүүжилттэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, тогтоомж

1. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Газрын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2. Монгол Улсын Олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол Олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

1/ “тусгай хамгаалалттай газар нутаг” гэж байгалийн унаган төрхийг хадгалах, экологийн тэнцвэрт байдлыг хангах, ховор, нэн ховор амьтан, ургамал, байгаль, түүх, соёлын өв бүхий газар нутгийг хамгаалах, нөхөн сэргээх, экосистемийн иж бүрдэл, экосистемийн үйлчилгээ, үнэ цэнийг алдагдуулахгүй байх зорилгоор энэ хуульд заасны дагуу улсын болон орон нутгийн хамгаалалтад тусгайлан авсан газар нутгийг;

2/ “тусгай хамгаалалттай газар нутгийн тогтолцоо” гэж улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газруудын менежментийн үйл явцыг бүртгэх, хянах, нэгдмэл удирдлага, мэдээллээр хангах, зохицуулах, уялдуулах нэгдсэн тогтолцоог;

3/“тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент” гэж тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалахтай холбоотой байгаль, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг судлах, төлөвлөх, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, хяналт үнэлгээ хийх, үр дүнг тооцох үйл явцыг талуудын оролцоотойгоор, үр ашигтай, цогц байдлаар удирдан зохион байгуулахыг;

5/ “тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөө” гэж тухайн тусгай хамгаалалттай газрын менежментийн зорилго, зорилт, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, удирдлага зохион байгуулалт, хүний нөөц, санхүүжилт, үр дүнгийн шалгуурыг тодорхойлсон, энэ хуульд заасан эрх бүхий байгууллагын баталсан, дунд болон богино хугацааны баримт бичгийг;

6/ “экосистем” гэж өөр хоорондоо идэш тэжээлийн хэлхээгээр холбогдсон бүх амьд бие, тэдгээрийн бодисын солилцоо энергийн хувиралд оролцох орчин тойрны амьгүй бүрэлдэхүүн хэсгүүдийн нэгдмэл тогтолцоог;

7/ “Экосистемийн үйлчилгээ” гэж тусгай хамгаалалттай газар нутгийн байгалийн үзэсгэлэнт байдал, түүний ой, ус, амьтан, ургамал болон бусад нөөц баялаг, түүх, соёлын дурсгал нь үйлчлүүлэгч, амрагч, зорчигч, аялагчдын эрүүл мэнд, алжаалаа тайлах, таашаал авах, танин мэдэхүйд үзүүлэх нөлөөллийг;

8/ “тусгай хамгаалалттай газар нутгийн дотоод бүс” гэж тухайн тусгай хамгаалалттай газрын хилийн цэсийн дотор орших байгалийн хэв шинжийг төлөөлөх онцлог, ховор, нэн ховор амьтан, ургамал, түүх, соёлын өв, дурсгалт зүйлийг хамгаалах, байгалийн нөөцийн зохистой ашиглалтын шаардлагыг харгалзан тогтоосон, хоорондоо хамгаалалтын ялгаа бүхий дэглэмтэй газрыг;

-

9/ “хамгаалалтын захиргаа” гэж улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын менежментийг хариуцан хэрэгжүүлэх үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага, эсхүл энэ хуульд заасан эрх бүхий байгууллагаас эрх олгосон, гэрээний үндсэн дээр менежментийг хариуцан хэрэгжүүлж буй байгаль хамгаалах мэргэшсэн байгууллагыг;

10/ “тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүс” гэж тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлж байгаа болон үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг багасгах, улмаар арилгах, урьдчилан сэргийлэх зорилгоор ногоон хөгжлийн зарчимд нийцүүлэн энэ хуульд заасан шалгуурыг үндэслэн тогтоосон экологийн бүс нутгийг;

11/ “тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын хамтын менежмент” гэж тухайн тусгай хамгаалалттай газар нутаг, түүний орчны бүсийг хамгаалах зохистой ашиглах үүрэг, зорилго, сонирхол бүхий төрийн, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн нөхөрлөлүүд тодорхой нөхцөл, болзол бүхий гэрээний үндсэн дээр харилцан ашигтай хамтран ажиллахыг;

12/ “Байгалийн нөөцийн зохистой ашиглалт” гэж байгалийн нөөцийг тэдгээрийн жам ёсоор өсөх, нөхөн сэргэх боломжийг алдагдуулахгүйгээр судалгаа, төлөвлөгөөнд үндэслэн ашиглахыг.

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН СҮЛЖЭЭ

4 дүгээр зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн ангилал

1.Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ нь улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгаас бүрдэх бөгөөд тэдгээр нь хамгаалалтын зорилго, дэглэмийг харгалзан тогтоосон ангилалтай байна

2. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийг дараах байдлаар ангилна:

- 1/ дархан цаазат газар;
- 2/ байгалийн цогцолборт газар;
- 3/ байгалийн нөөц газар
- 4/ дурсгалт газар

3. Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг нь энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан ангилалд хуваагдана.

5 дугаар зүйл. Дархан цаазат газар

1. Байгаль, экологийн тэнцвэрт байдлыг хангахад онцгой үүрэгтэй, унаган төрхөө хадгалсан, ховордсон амьтан, ургамал, байгаль, түүх, соёлын үнэт өв бүхий, шинжлэх ухаан, танин мэдэхүйн ач холбогдолтой, хойч үедээ өвлүүлэн үлдээх зорилгоор хамгаалалтын онцгой дэглэм тогтоосон газар нутгийг дархан цаазат газар гэнэ.

6 дугаар зүйл. Байгалийн цогцолборт газар

1. Байгалийн унаган төрхөө харьцангуй хадгалсан, өвөрмөц тогтоц, түүх соёлын дурсгал бүхий, экосистемийн цогц байдлыг агуулсан, үндэсний бахархал болсон, түүх, соёлын болон экологийн танин мэдэхүйн онцгой ач холбогдолтой, байгалийн аялал жуулчлал, амралт, сувилал хөгжүүлэх зорилгоор хамгаалалтад авсан газар нутгийг байгалийн цогцолборт газар гэнэ.

7 дугаар зүйл. Байгалийн нөөц газар

1. Байгалийн онцлог хэв шинж, иж бүрдлийг хадгалан хамгаалах, байгалийн тодорхой нөөцийн өсөн үржих нөхцөлийг бүрдүүлэх ач холбогдол бүхий газар нутаг, доройтсон орчныг нөхөн сэргээх зорилгоор хамгаалалтад авсан үндэсний болон олон улсын ач холбогдол бүхий газар нутгийг байгалийн нөөц газар гэнэ.

2. Байгалийн нөөц газрыг дараах төрөлд хуваана:

1/ байгалийн онцлог хэв шинжийг унаган төрхөөр нь хадгалах, байгалийн нөхөн сэргээгдэх нөөцийг зохистой ашиглах зорилго бүхий байгалийн иж бүрдлийн нөөц газар;

2/ амьтан, ургамлын нөхөн үржих, нүүдэллэн шилжих нөхцөлийг бүрдүүлэх зорилго бүхий биологийн нөөц газар;

3/ эртний амьтан, ургамлын ховор олдворыг байгалийн байдлаар нь хадгалах зорилго бүхий палеонтологийн нөөц газар;

4/ газрын өвөрмөц тогтоц, илэрц, тэдгээрийн бүтцийг байгалийн байдлаар нь хадгалах зорилго бүхий геологийн нөөц газар;

5/ томоохон гол мөрний урсац бүрэлдэх эх, үндэсний ач холбогдол бүхий гадаргын болон гүний цэнгэг усны нөөц, олон улсын ач холбогдол бүхий ус намаграхаг орчныг хамгаалах зорилго бүхий усны нөөц газар;

6/ баянбүрд, заган болон төгөл ойг хамгаалах зорилго бүхий ойн нөөц газар;

7/ доройтсон орчныг нөхөн сэргээх зорилго бүхий нөөц газар

8 дугаар зүйл. Дурсгалт газар

1. Байгалийн өвөрмөц тогтоц, түүх, соёлын дурсгалыг уламжлан хадгалагдсан байдлаар нь өвлөн үлдээх зорилгоор хамгаалалтад авсан үндэсний болон олон улсын ач холбогдол бүхий газар нутгийг дурсгалт газар гэнэ.

2. Дурсгалт газрыг дараах төрөлд хуваанангилна:

1/ байгалийн дурсгалт газар;

2/ түүх, соёлын дурсгалт газар.

3. Байгалийн дурсгалт газарт өвөрмөц тогтоц, илэрц бүхий хүрхрээ, хясаа, хавцал, агуй, хад цохио, явар, цонж, элсэн манхан, солир, солирын цар, өрх, галт уулын тогоо болон төгөл мод, рашаан булаг, баянбүрд зэрэг газрыг хамруулж болно.

4. Түүх, соёлын дурсгалт газарт Соёлын өвийн тухай хуулийндугаар зүйлийн-д заасан эртний хүний оромж, отог, сууц, агуй, сүг зураг, хадны бичээс, буган болон хүн чулуун хөшөө, булш бунхан, хиргэсүүр, эртний хүн, амьтан, ургамлын чулуужсан олдвор, ул мөрийг хадгалсан газар, хот, суурины үлдэгдэл, балгас, хэрэм, цайз, суваг шуудуу, далан, эртний зэр зэвсэг хийж байсан орд, уламжлалт зан үйлтэй холбоотой уул, овоо, тахилга болон түүхэн чухал үйл явдал болсон газар зэргийг хамааруулж болно.

9 дүгээр зүйл. Орон нутгийн тусгай хамгаалалттай газар

1. Аймаг, нийслэл, сум, дүүрэг өөрийн нутаг дэвсгэр дэх газар нутгийг дараах ангилалаар орон нутгийн тусгай хамгаалалтад авна.

1/ энэ хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан, эсвэл тодорхой зорилго, тусгай дэглэмээр зохистой ашиглах шаардлага бүхий байгалийн нөөц газар,

2/ энэ хуулийн 8 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэгт заасан орон нутгийн ач холбогдол бүхий байгаль, түүх, соёлын дурсгалт газар,

3/ хамгаалалтыг сайжруулах зорилгоор ой, усны тухай болон бусад хуулиар хамгаалагдсан ой, усны, бусад нөөц газар,

2. Газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах, гаргах болон тэдгээрийн хамгаалалтын нийтлэг дэглэмийг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан журмаар зохицуулна.

3. **Орон нутгийн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын горимыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал баталж, мөрдүүлнэ.**

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ДОТООД БҮС,

ХАМГААЛАЛТЫН ДЭГЛЭМ, ГОРИМ

10 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн дотоод бүс

1. Дархан цаазат болон байгалийн цогцолборт газар нь дотоод бүсчлэлтэй байх ба бусад ангилалын тусгай хамгаалалттай газруудад дотоод бүсчлэл тогтоож болно.

2. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн дотоод бүсийг тогтоох шалгуур үзүүлэлт, журмыг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн тусгай хамгаалалттай газрын дотоод бүсийг тогтоох шалгуур үзүүлэлтийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

11 дүгээр зүйл. Дархан цаазат газрын дотоод бүс

1. Дархан цаазат газрыг дотор нь дараах бүсэд хуваана:

1/ онгон бүс;

2/ хамгаалалтын бүс;

3/ хязгаарлалтын бүс.

12 дугаар зүйл. Онгон бүсийн дэглэм

1. Онгон бүсэд байгалийн онгон байдал, унаган төрх, экологийн хэв шинжийг нь хадгалах шаардлагад нийцүүлж зөвхөн хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлнэ.

2. Онгон бүсэд байгалийн төлөв байдлыг хөндөхгүйгээр зөвхөн ажиглах хэлбэрээр судалгаа, шинжилгээний ажил явуулах ба түүнээс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

13 дугаар зүйл. Хамгаалалтын бүсийн дэглэм

1.Хамгаалалтын бүсэд энэ хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2 дугаар заалтад зааснаас гадна онгон бүсийн хамгаалалтыг баталгаажуулах зорилготой үйл ажиллагааг ургамал, амьтны аймгийн өсөж үржих нөхцөлийг хангах, байгалийн гамшгаас учирсан хор уршгийг арилгахтай холбогдсон биотехникийн арга хэмжээг тодорхой төлөвлөгөө, зөвшөөрлийн дагуу байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр хэрэгжүүлнэ.

14 дүгээр зүйл. Хязгаарлалтын бүсийн дэглэм

1. Хязгаарлалтын бүсэд байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр зохих зөвшөөрөлтэйгээр дараах үйл ажиллагаа явуулж болно:

1/ энэ хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйл ажиллагаа;

2/ хөрс, ургамлын бүрхэвчийг нөхөн сэргээх;

3/ эрх бүхий мэргэшсэн байгууллага, нутгийн иргэдийн нөхөрлөл батлагдсан журмын дагуу ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх, байгалийн жамаар нөхөн сэргэлтийг дэмжих, ойжуулах;

4/ ургамлын нөөц, тархац тогтоох, ан амьтны тооллого хийх, тэдгээрийн сүргийн бүтцийг зохицуулах, ан амьтныг сэргээн нутагшуулах үйл ажиллагааг батлагдсан менежментийн төлөвлөгөө, аргачлалын дагуу явуулах;

5/ рашаан усыг ахуйн болон эмчилгээний зориулалтаар ашиглах;

6/ байгалийн аялал жуулчлалыг батлагдсан замнал, зохих журмын дагуу зохион байгуулах;

7/ аялах, ажиглалт, судалгаа шинжилгээ хийх зориулалтаар зөвшөөрөгдсөн газарт түр отоглох;

8/ зөвшөөрлийн дагуу шинжлэх ухаан, танин мэдэхүй, арилжааны зориулалтаар зураг авах, дуу, дүрсний бичлэг хийх;

9/ уул, овоо тахих, уламжлалт зан үйлийг байгальд халгүй хэлбэрээр үйлдэх;

10/ нөөцийг нь тогтоосны үндсэн дээр иргэд ахуйн хэрэгцээндээ зориулан ойн дагалт баялаг, эмийн болон хүнсний ургамлыг зохих журмын дагуу түүж ашиглах;

11/ орчны бүсэд ган, зудын нөхцөл байдал бий болсон тохиолдолд тогтоосон журмын дагуу, тодорхой зөвшөөрөл, нөхцөл болзолтойгоор уламжлалт аргаар мал бэлчээрлүүлэх;

15 дугаар зүйл. Дархан цаазат газартхориглохүйл ажиллагаа

1. Дархан цаазат газарт энэ хуулийн 14 дүгээр зүйлд зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

1/ газар хагалах, тэсэлгээ хийх, газрын тос, ашигт малтмал хайх, олборлох, элс, хайрга чулуу авах, байгалийн төлөв байдлыг өөрчлөх;

2/ тухайн газрын байгалийн төрхийг өөрчлөх, экосистемийн тогтолцоог алдагдуулах, ховор амьтан ургамлын байршил, тархац, шилжилт нүүдлийг таслах, дархан цаазат газрыг таллан хуваах байдалтай авто болон төмөр зам тавих, засах;

3/ байгалийн дагалт баялаг, эм, хүнснийболон техникийн зориулалттай ургамал, мод, заг, бутлаг ургамал, зэгс, шагшуурга зэргийг үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх;

4/ энэ хуулийн 14 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтад зааснаас өөр зориулалтаар амьтан агнах, барих, үргээх, тэдгээрийн үүр, ичээ, нүх, ноохойг хөндөх, эвдэж сүйтгэх;

5/ хөнөөлт шавьж, мэрэгчид, гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэдгээртэй тэмцэх ажлыг байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх арга, техник, бодис ашиглан хэрэгжүүлэх;

6/ хөрс, ус, агаар бохирдуулах аливаа үйл ажиллагаа явуулах;

7/ хязгаарлалтын бүсээс бусад бүсэд нохой дагуулж, буу авч явах;

8/ метал хайгч, химийн хорт болон тэсрэх бодис авч явах;

9/онцгой байдал үүссэнээс бусад тохиолдолд тухайн газрын хамгаалалтын захиргаанаас урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр агаарын хөлгөөр буулт хийх, хэт нам өндрөөр нислэг үйлдэх;

10/ өвөлжөө, хаваржаа, намаржаа, зуслангийн болон бусад барилга байгууламж барих, зохих зөвшөөрөлгүй мал бэлчээрлүүлэх;

11/ нуур, цөөрөм, мөрөн, гол, горхи, булаг шанд, рашаан зэрэг ил задгай усыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах;

12/ хууль тогтоомж болон хамгаалалтын горимоор хориглосон, байгаль орчинд сөрөг нөлөөлөх бусад үйл ажиллагаа явуулах.

16 дугаар зүйл. Байгалийн цогцолборт газрын дотоод бүс

1. Байгалийн цогцолборт газрыг байгалийн хэв шинж, ховордсон амьтан, ургамлын байршил, байгаль, түүх, соёлын өв, дурсгалыг нь хадгалах шаардлага, аялал, жуулчлал хөгжүүлэх нөхцөл зэргийг харгалзан дараах бүсэд хуваана:

1/ хамгаалалтын бүс

2/ аялал,жуулчлалын бүс;

3/ хязгаарлалтын бүс.

17 дугаар зүйл. Хамгаалалтын бүсийн дэглэм

1. Хамгаалалтын бүсэд байгалийн унаган төрх болон экологийн тэнцвэрт байдлыг хадгалах шаардлагад нийцүүлэн байгальд сөрөг нөлөөгүй арга, хэлбэрээр судалгаа, шинжилгээний ажил явуулах, ургамал, амьтны өсөж үржих нөхцөлийг хангах, хөрсийг нөхөн сэргээх, ой, хээрийн түймэр, мэрэгч, хөнөөлт шавьжны тархалтаас урьдчилан сэргийлэх, тэдгээртэй тэмцэх, учирсан хохирлыг арилгах, арга хэмжээ авна.

18 дугаар зүйл. Аялал, жуулчлалын бүсийндэглэм

1. Аялал, жуулчлалын бүсэд байгаль орчинд нь сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр зохих зөвшөөрөлтэйгээр дараах үйл ажиллагаа явуулж болно:

1/ энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-12 дахь заалт, 17 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйл ажиллагаа явуулах;

2/ батлагдсан замналын дагуу байгалийн аялал жуулчлал явуулахад шаардлагатай аялалын жим, отоглох цэг, тэмдэг, тэмдэгжүүлэлтийг байгалийн өнгө үзэмжийг алдагдуулахгүйгээр засаж тохижуулах;

2/ зөвшөөрөгдсөн газар холбогдох хуульд заасан нөхцөл, болзлын дагуу ахуйн болон спорт агнуурын зориулалтаар загас барих.

19 дүгээр зүйл. Хязгаарлалтын бүсийн дэглэм

1. Хязгаарлалтын бүсэд дараах үйл ажиллагаа явуулж болно:

1/ энэ хуулийн 18 дугаар зүйлийн 1 дүгээр хэсгийн 1, 2 дугаар заалтад заасан үйл ажиллагаа;

2/ батлагдсан журам, зөвшөөрлийн дагуу уламжлалт аргаар мал аж ахуй эрхлэх;

3/ тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчинд сөрөг нөлөөгүй, байгалийн өнгө үзэмжийг алдагдуулахааргүй, зөөвөрлөх боломжтой барилга, дэд бүтцийн байгууламжийг батлагдсан зураг, төсөл, стандартын дагуу барих, зориулалтын дагуу ашиглах;

4/ байгалийн аялал жуулчлал болон энэ хуулийн ___ дүгээр зүйлийн ___дахь хэсэгт заасан ажил үйлчилгээ явуулахад шаардагдах барилга байгууламжийг батлагдсан зураг төсөл, стандартын дагуу барих, зориулалтын дагуу ашиглах;

5/ батлагдсан замналын дагуу тээврийн хэрэгслийн зогсоол, спорт, олон нийтийн арга хэмжээнд шаардлагатай талбайг засч тохижуулах;

6/ иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн нөхөрлөл өөрийн ашиглаж буй газраа батлагдсан журам, арга зүйн дагуу нөхөн сэргээх, ойжуулах, зэрлэг амьтан өсгөн үржүүлэх, цэцэрлэгт хүрээлэн, усан сан, цөөрөм байгуулах;

7/ нутгийн иргэд ахуйн зориулалтаар 0.1[BB1] га хүртэл талбайд хүнсний ногоо, жимс тарих

20 дугаар зүйл. Байгалийн цогцолборт газарт хориглох үйл ажиллагаа

1. Байгалийн цогцолборт газарт энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-9 ба 11,12 дахь заалтад зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

1/ газрын тос, ашигт малтмал хайх, олборлох, тэсэлгээ хийх, элс, хайрга чулуу авах, байгалийн төлөв байдлыг өөрчлөх;

2/ зөвшөөрөлгүй болон зориулалтын бусаар газар ашиглах, ажил, үйлчилгээ эрхлэх, үйл ажиллагаа явуулах, бэлчээрийн даацаас хэтэрсэн мал бэлчээрлүүлэх;

21 дүгээр зүйл. Байгалийн нөөц газрын хамгаалалтын дэглэм

1. Байгалийн нөөц газарт тухайн газрын байгалийн хэв шинж, төрх байдал, амьтан, ургамлын аймгийн байршил, өсөлт, үржилт, нүүдэл, шилжилтэд сөрөг нөлөөгүйгээр энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан үйл ажиллагаа явуулж болох ба зохих судалгаа, төлөвлөлтийн үндсэн дээр байгалийн нөөцийг зохистой ашиглаж болно
2. Байгалийн нөөц газарт тухайн газрыг хамгаалалтад авсан зорилго, хамгаалалтын горимд нийцээгүй барилга, дэд бүтцийн байгууламж барих, ашигт малтмал хайх, олборлох, мод, заг, бутлаг ургамал, зэгс, шагшуурга, байгалийн хадланг үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэх, зөвшөөрөлгүйгээр ан амьтан агнах, барих, нуур, цөөрөм, гол, горхины усыг бохирдуулах, байгалийн унаган төрхийг өөрчлөх, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

22 дугаар зүйл. Дурсгалт газрын хамгаалалтын дэглэм

1. Дурсгалт газарт зохих судалгаа, төлөвлөлтийн үндсэн дээр зөвшөөрөлтэйгээр байгалийн нөөцийг зохистой ашиглах, аялал жуулчлал, уламжлалт зан үйл, танин мэдэхүйн үйл ажиллагаа явуулах, байгаль, түүх соёлын үнэт зүйлсийг хамгаалах арга хэмжээ хэрэгжүүлнэ.

2. Дурсгалт газарт дараах үйл ажиллагааг хориглоно.

1\ Дурсгалт газрын хилийн цэсийн дотор аливаа байгууламж барих болон байгаль, түүх, соёлын өв, дурсгалт зүйлээс 3.0 километрээс багагүй зайд түүний сүр бараа, үзэмжийг дарах барилга, байгууламж барих,

2\ дурсгалт газрын хилийн цэсээс гадагш 5.0 километрээс багагүй зайд, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох,

3\ байгаль, түүх, соёлын өв, дурсгалт зүйлийг хөндөх, эвдэх, буулгах, тэдгээрт хохирол учруулахуйц бусад үйл ажиллагаа

23 дугаар зүйл. Орон нутгийн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын дэглэм

1. Орон нутгийн тусгай хамгаалалттай газарт энэ хуулийн 21, 22 дугаар зүйлд заасан дэглэмийг нэгэн адил мөрдөнө.

24 дүгээр зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын горим

1. Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар бүр тухайн газар нутгийн байгаль, нийгэм, эдийн засгийн онцлогийг харгалзан тогтоосон хамгаалалтын горимтой байна.
2. Дархан цаазат болон байгалийн цогцолборт газрын хамгаалалтын горимыг Засгийн газар, байгалийн нөөц болон дурсгалт газрын хамгаалалтын горимыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлан мөрдүүлнэ.
3. Орон нутгийн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын горимыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батлан мөрдүүлнэ.
4. Тухайн тусгай хамгаалалттай газар нутаг нь дэлхийн байгаль, соёлын өвийн жагсаалт, Хүн ба Шим мандлын нөөц газрын сүлжээ болон Рамсарын конвенцийн хавсралтад бүртгэгдсэн бол тухайн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын горимд холбогдох конвенцийн заалтыг мөрдлөг болгоно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ОРЧНЫ БҮС

25 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүс

1. Дархан цаазат болон байгалийн цогцолборт газар нь орчны бүстэй байна. Орчны бүс нь улсын тусгай хамгаалалттай газрын хилийн цэсийн гадна байна.
2. Байгалийн нөөц газар, дурсгалт газар болон орон нутгийн тусгай хамгаалалттай газарт шаардлагатай бол орчны бүс тогтоож болно.

26 дугаар зүйл. Орчны бүсийг тогтоох шалгуур

1. Тусгай хамгаалалттай газрын орчны бүсийг тогтоохдоо дараах шалгуурыг үндэслэнэ:
 - 1/байгаль орчин, нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад онцгой ач холбогдол бүхий газар нутаг;
 - 2 Биологийн олон янз байдлын тархац нутаг, тэдгээрийн нүүдэллэх, шилжих зам, нутагшиж болох газар нутаг;
 - 3/байгалийн нөөцийн ашиглалт нь тухайн тусгай хамгаалалттай газрын экологийн тэнцвэрт байдалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй газар нутаг;
 - 4/ тусгай хамгаалалттай газрын экосистемд нөлөөлөх ой, гол, голын эх, сав газар;
 - 5/ нутгийн хүн ам, айл өрх, малын нягтрал нь бэлчээрийн даац, усны хангамжийн хүрэлцээнд сөрөг нөлөө үзүүлж байгаа болон үзүүлж болзошгүй газар нутаг;
 - 6/ байгаль орчныг бохирдуулах эх үүсвэрийн байршил, нөлөөллийн цар хүрээ;
 - 7/ нийгэм, эдийн засгийн хөгжил нь тухайн тусгай хамгаалалттай газар, түүний орчны байгаль, байгалийн нөөцөөс онцгой хамаарал бүхий суурин газар;
 - 8/Байгалийн өвөрмөц тогтоц, түүх соёлын дурсгал бүхий газар

9/ Хэт доройтсон, нөхөн сэргээх шаардлагатай газар нутаг

27 дугаар зүйл. Орчны бүсийн хилийн цэсийг тогтоох

1. Тухайн газрыг тусгай хамгаалалтад авснаас хойш нэг жилийн дотор багтаан сум, дүүргийн Засаг дарга Тусгай хамгаалалттай газрын орчны бүсэд хамруулах газар нутгийн хилийн цэсийг тухайн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны саналыг үндэслэн энэ хуулийн 26 дугаар зүйлд заасан шалгуурын дагуу боловсруулж, орчны бүс тогтоох зорилго, ач холбогдлын талаар тухайн сум, дүүргийн иргэдэд танилцуулж, тэдний саналыг тусган, саналаа тухайн сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжилна.
2. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тусгай хамгаалалттай газрын орчны бүсийн хилийн цэсийг тогтоох тухай Засаг даргын саналыг хүлээн авснаас хойш 3 сарын дотор багтаан хэлэлцэн, батлана.
3. Иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь орчны бүс тогтоосон тухай шийдвэр болон түүнд хамрагдсан газар, ус, амьтан ургамлын нөөцийн тухай мэдээлэл, хилийн цэсийн цэгүүдийг 1: 500000 масштабын газрын зурагт тусган хавсаргаж, тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

28 дугаар зүйл. Орчны бүсийн хөгжлийн төлөвлөгөө

1. Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүс нь түүний зорилго, ногоон эдийн засгийн болон орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдсан, байгалийн нөөцийг зохистой ашиглах, нөхөн сэргээхэд талуудын оролцоог хангах, нутгийн иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжих, орчны бүсийг эко бүс нутаг болгон хөгжүүлэхэд чиглэсэн хөгжлийн төлөвлөгөөтэй байна.
2. Орчны бүсийн хөгжлийн төлөвлөгөөг орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан түүний дэд хэсэг болгон хэрэгжүүлэх ба боловсруулах аргачлалыг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлана
3. Орчны бүс нутгийн хөгжлийн төлөвлөгөөг тухайн сум дүүргийн Засаг дарга нь Хамгаалалтын захиргаа, Орчны бүсийн зөвлөл, сумын иргэдийн төлөөлөлтэй хамтран боловсруулж, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж батлуулан хэрэгжүүлнэ.
4. Орчны бүсийн хөгжлийн төлөвлөгөөнд дараах зүйлийг тусгана:

1/орчны бүсийн байгаль, нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдал, хэтийн төлөв, аж ахуйн үйл ажиллагаанаас тусгай хамгаалалттай газар нутаг, орчны бүсэд үзүүлж буй болон үзүүлж болзошгүй нөлөөлөл, тэдгээрийг багасгах, арилгах арга хэмжээ;

2/ Орчны бүсийн иргэд, аж ахуйн нэгж, нөхөрлөлүүд байгалийн нөөц ашиглахад байгальд халгүй, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, хөгжүүлэхийг дэмжих арга хэмжээ

3/орчны бүсэд амьтан, ургамал, газар, байгалийн нөөц баялгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхчиглэл, хэлбэр, хэрэгжүүлэх арга хэмжээ;

4/орчны бүсээр дамжин өнгөрдөг амьтдын нүүдэллэх зам, өсөж үржих газар орчныг хамгаалах арга хэмжээ;

5/ орчны бүсийн байгаль, нийгэм эдийн засгийн хөгжлийг хангах, нутгийн иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжихэд талуудын үүрэг, хариуцлага, оролцоог нэмэгдүүлэх арга зам, мөрдөх зарчмууд;

6/орчны бүсийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардал, санхүүжүүлэх эх үүсвэр, хэрэгжилтийг хянах, үнэлэх тогтолцоо;

29 дүгээр зүйл. Орчны бүсийн зөвлөл

1. Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн зорилгыг хангах, тухайн бүс нутгийн хөгжлийг ногоон эдийн засгийн хөгжлийн бодлого, байгалийн нөөцийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, нутгийн иргэдийн оролцоог өргөжүүлэх шаардлагад уялдуулан эко бүс нутгийн хөтөлбөр, орчны бүсийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасан тусгай хамгаалалттай газрын хамтын менежментийг удирдан зохицуулах, орон нутгийн оролцогч талуудад зөвлөн туслах үүрэг зорилго бүхий орон тооны бус Орчны бүсийн зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ ажиллана.

2. Зөвлөл нь сондгой тооны гишүүдтэй, дараах бүрэлдэхүүнтэй байна:

1/сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хоёр төлөөлөл;

2/нутгийн иргэдийн нөхөрлөлүүдийн гураваас доошгүй төлөөлөл;

3/тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны хоёр төлөөлөл;

4/тухайн бүс дэх усны сав газрын захиргааны нэг төлөөлөл;

5/ орчны бүсэд байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын нэг төлөөлөл;

6/ тухайн бүсэд байгалийн нөөц ашиглах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн хоёр төлөөлөл;

3. Тухайн сум дүүрэг дэх орчны бүсийн зөвлөлийг зөвлөлийн гишүүдийн дундаас сонгогдсон дарга удирдана. Орчны бүсийн зөвлөлийн даргын санал болгосноор нарийн бичгийн даргыг томилох ба нарийн бичгийн дарга нь орон тооны байж болно.

4. Орчны бүсийн зөвлөл нь төрийн бус байгууллагын статустай байж болох бөгөөд гишүүдийн хурлаар баталсан дүрэм, улсын бүртгэлийн гэрчилгээ, тэмдэг, харилцах данстай байна.

5. Тусгай хамгаалалттай газар нутаг нь хэд хэдэн аймаг, сум, дүүргийн нутаг дэвсгэр хамарсан тохиолдолд орчны бүсийн нэгдсэн зөвлөл байгуулж болно.

6. Зөвлөл дараах эрх, үүрэгтэй байна:

1/ энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасан тусгай хамгаалалттай газрын хамтын менежментийг хэрэгжүүлэхэд орон нутгийн оролцогч талуудын үүрэг, хариуцлага, оролцоог хангахад сум дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад зөвлөн туслах;

2/ тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд олон нийтийн хяналтыг зохион байгуулах;

3/ тусгай хамгаалалттай газар нутгийн хамтын менежментийг хэрэгжүүлэхэд талуудын үүрэг, оролцоог хангуулах;

4/ орчны бүсийн хөгжлийн төлөвлөгөөг тусгай хамгаалалттай газрын менежментийн төлөвлөгөө, сум, дүүргийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулахад туслах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

5/ орчны бүсийн сангийн үйл ажиллагааг эрхлэн түүнд хөрөнгө төвлөрүүлэх хуваарилах, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих ажлыг тогтоосон журмын дагуу зохион байгуулах;

6/ тусгай хамгаалалттай газар нутгийн тухай, байгаль орчны тухай хууль тогтоомжийг сурталчилах;

7\ Зөвлөлийн үйл ажиллагаа, үр дүн, сангийн төвлөрүүлэлт, зарцуулалтын тайланг гаргаж сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд жилд нэгээс доошгүй удаа тайлагнах.

30 дугаар зүйл. Орчны бүсийн сан

1. Зөвлөл нь тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтыг дэмжих, орчны бүсийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг дэмжих зорилго бүхий орчны бүсийн сан /цаашид "сан" гэх/-г байгуулж ажиллана.

2. Сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

1/сум, дүүрэгт байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын 10-аас доошгүй хувь;

2/орчны бүсэд байгаль орчин болон байгалийн нөөцөд учруулсан хохирлын нөхөн төлбөрийн орлогын 10-аас доошгүй хувь

3/ орчны бүсэд ус бохирдуулсны төлбөрийн орлогын 10-аас доошгүй хувь

4/ орчны бүсэд байгаль орчны хууль тогтоомж зөрчсөнөөс захиргааны журмаар хураагдсан эд зүйлсийг борлуулсны орлогын 20 хувь

5/ иргэд, байгууллагын хандив, тусламж

6/ Орчны бүсийн сангаас санхүүжүүлэн хэрэгжүүлсэн үйл ажиллагааны орлого

7/ бусад орлого

3. Энэ хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1-4-т заасан орлогоос уг санд төвлөрүүлэх хувь хэмжээг тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

4. Орчны бүсийн сангийн хөрөнгийг орчны бүсийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх дор дурьдсан арга хэмжээнд зарцуулна:

1/ бэлчээрийн талхагдалт, цөлжилт, гол, горхи, булаг шанд, рашаан усны ундарга багасах, ширгэх, бохирдох, ой, хээрийн түймэр, ой, ургамлын хөнөөлт шавьж, мэрэгчдийн тархалт зэрэг уур амьсгалын өөрчлөлт хүний хүчин зүйлийн сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх, тэдгээртэй тэмцэх, байгалийн аюул, гамшгаас урьдчилан сэргийлэх, учирсан хохирлыг арилгах арга хэмжээ;

2/ газрын хэвлий, газар, ус, ой, амьтан, ургамлын нөөцийг хамгаалах, тогтвортой ашиглах, доройтсон орчныг нөхөн сэргээх;

3/ байгалийн нөөц ашиглахад байгальд халгүй, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, хөгжүүлэхийг дэмжих арга хэмжээ;

4/ эко-бүс нутгийн хөгжлийг дэмжих, цэвэр үйлдвэрлэл, эко-бүтээгдэхүүн үйлдвэрлэх төсөл, хөтөлбөрийг дэмжин хэрэгжүүлэх;

5/ нутгийн иргэдийн байгаль орчны болон дэвшилтэт технологийн мэдлэг, мэдээлэл, боловсролыг сайжруулах чиглэлийн сургалт, сурталчилгаа явуулах;

6/ Орчны бүсийн зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх;

5. Орчны бүсийн зөвлөл болон санг байгуулах, ажиллуулах, санг аривжуулах, зарцуулах аргачлал, журмыг тусгай хамгаалалттай газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулга батална.

ТАВДУГААР БҮЛЭГ

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ТАЛААРХ

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ

31 дүгээр зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

1. Улсын Их Хурал тусгай хамгаалалттай газар нутгийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах, тусгай хамгаалалттай газрын сүлжээг өргөжүүлэн хөгжүүлэх талаарх төрийн бодлогыг тодорхойлох,

2/ засгийн газрын өргөн мэдүүлснээр газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах, өргөтгөх тухай шийдвэр гаргаж, хилийн цэсийг батлах, эдгээр газрыг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тодорхой ангилалд хамруулах, ангилалыг өөрчлөх;

32 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх

1. Засгийн газар тусгай хамгаалалттай газар нутгийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулж, хангах;

2/ тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх төрийн бодлого, үндэсний хөтөлбөрийн үзэл баримтлалд нийцүүлэн салбар хоорондын уялдааг хангах;

3/ газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах, өргөтгөх тухай саналыг боловсруулж, Улсын Их Хуралд оруулж шийдвэрлүүлэх;

4/ тусгай хамгаалалттай газар нутгийг байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулаас сэргийлэх, тэдгээрээс учирсан хор уршгийг арилгах талаар салбар хоорондын уялдааг хангаж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүчийг нэгтгэн зохион байгуулж, шаардлагатай арга хэмжээ авах;

5/ тусгай хамгаалалттай газар нутаг, түүний орчны бүсийг хөгжүүлэх, экологийн аюулгүй байдал, байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;

6/ хил дамнасан тусгай хамгаалалттай газар байгуулах талаар хөрш орнуудтай хамтарч ажиллах, хил дамнасан тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах хамтарсан менежментийн төлөвлөгөөг батлах

33 дугаар зүйл. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

1. тусгай хамгаалалттай газар нутгийн талаархи төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангах

2. газар нутгийг тусгай хамгаалалтанд авах, өргөтгөх, тодорхой ангилалд хамруулах, хилийн цэсийг тогтоох асуудлыг тухайн сум дүүргийн ИТХ-ын саналыг үндэслэн газрын асуудал хариуцсан төрийн

захиргааны байгууллагатай хамтран шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулан Засгийн газарт өргөн мэдүүлэх

3. тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага байгуулж, даргыг томилж, түүний удирдлага, бүтэц, зохион байгуулалтыг тодорхойлох, санхүүжилтийг баталгаажуулах, үйл ажиллагаанд хяналт тавих;

4. тусгай хамгаалалттай газар нутагтай холбоотой аливаа асуудлаар төр, хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагатай бодлогын түвшинд хамтран ажиллах, чиглэл өгөх, салбар дундын уялдааг хангах;

5. тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөний аргачлал батлах;

6. хамтын удирдлагын гэрээ байгуулах ;

7. хуульд заасан асуудлаар холбогдох байгууллагатай хамтран дүрэм, журам, аргачлал батлах;

8. тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент, удирдлага зохион байгуулалттай холбогдох асуудлаар шаардлагатай тохиолдолд тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад эрх, үүрэг шилжүүлэх;

9. тусгай хамгаалалттай нутгийн тогтвортой санхүүжилтийг бүрдүүлэх зорилгоор байгаль хамгаалах сангийн хүрээнд тусгай хамгаалалттай нутгийн хөгжлийн данс нээж ажиллуулах.

10. тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль орчны төлөв байдлын талаар мэргэжлийн дүгнэлт гаргах;

11. хуульд заасан бусад эрх

34 дүгээр зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх

1. Тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /цаашид "төрийн захиргааны байгууллага" гэх/ нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, олон улс, бүс нутгийн гэрээ, конвенцоор хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангах, энэ талаарх төслийг боловсруулах, батлуулах

2/ энэ хуулийн 28...дүгээр зүйлийн 5-д заасан үйл ажиллагааг явуулах журам, дүрэм, аргачлал боловсруулан батлаж мөрдүүлэх, хэрэгжилтэнд нь хяналт тавих;

3/ газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах тухай журам батлах, энэ хуульд заасан хамгаалалтын дэглэмийн хүрээнд улсын тусгай хамгаалалттай тухайн газрын хамгаалалтын горимыг батлах;

4/ тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль орчны төлөв байдлын талаар мэргэжлийн дүгнэлт гаргах;

5/ тусгай хамгаалалттай газрын менежментийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих;

6/ улсын тусгай хамгаалалттай газар нутгийн дэглэмийн дагуу зөвшөөрөгдсөн бүс дэх суурин газар, аялал жуулчлал, амралт сувилал хөгжүүлэх бодлого, ерөнхий төлөвлөгөөг байгаль, экологийн болон аялал жуулчлалын даац нөөцийн үнэлгээнд үндэслэн боловсруулж батлах;

7/ төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн үйл ажиллагааг зохицуулах, улсын тусгай хамгаалалттай газрын менежментийг гэрээний үндсэнд хариуцан хэрэгжүүлэх байгаль хамгаалах мэргэшсэн байгууллагыг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах, эрхийг шилжүүлэх;

8/ улсын тусгай хамгаалалттай газар нутгуудын нэгдсэн сүлжээний мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, хөтлөх;

9/ энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 9-т зааснаас бусад улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны даргыг томилох, чөлөөлөх, халах, сахилгын шийтгэл ногдуулах, ~~саяг~~ ажиглуулах, шилжүүлэх, шагнал урамшуулал олгох;

10/ тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг мэргэжлийн боловсон хүчин, мэргэжил арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах, ~~давтан~~ сургах, чадавхижуулах, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, хяналт тавих ажлыг зохион байгуулах;

11/ дэлхийн соёлын өвд хамрагдсан тусгай хамгаалалттай газар нутагт соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай гэрээ байгуулан хамтран ажиллах, дэлхийн байгалийн өвийн жагсаалт, олон улсын “Хүн ба шим мандлын нөөц газрын сүлжээ”, Олон Улсын гэрээ, конвенцийн хавсралтад оруулж бүртгүүлэх ажлыг зохион байгуулах;

12/ тусгай хамгаалалттай газар нутгийн нөөц даацад үндэслэн тодорхой зориулалт, болзол, нөхцөл, хугацаатайгаар газар түр ашиглах зөвшөөрөл олгох, хяналт тавих;

13/ улсын хил орчмын тусгай хамгаалалттай газар нутагт улсын хил хамгаалах байгууллага үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх журмыг хил хамгаалах төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлаж мөрдүүлэх;

14/ улсын тусгай хамгаалалттай газар нутагт ой, хээрийн түймэр, гамшигийн үед онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах журам баталж, мөрдүүлэх;

15/ тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний менежментийн үр ашиг, үр нөлөөнд мониторинг хийх журмыг батлан мөрдүүлэх [\[U2\]](#)

16/ хуульд заасан бусад эрх;

2. Тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад Яам, агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль нэгэн адил хамаарна.

35 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тусгай хамгаалалттай газар нутгийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ нутаг дэвсгэрийнхээ тодорхой хэсгийг улсын тусгай хамгаалалтад авах, өргөтгөх тухай саналыг дээд шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал буюу Засгийн газарт уламжлах;

2/ нутаг дэвсгэрийнхээ тодорхой хэсгийг холбогдох журмын дагуу орон нутгийн хамгаалалтад авах тухай шийдвэр гаргах, түүний хилийн цэс, хамгаалалтын дэглэмийг тогтоож, биелэлтийг хангах;

3/ улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа, тухайн шатны Засаг даргын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах;

4/ өөрийн нутаг дэвсгэр дэх орон нутгийн хамгаалалттай газар нутгийн хамгаалалт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар Засаг даргын болон хамгаалалтын захиргааны илтгэлийг хэлэлцэж, зохих шийдвэр гаргах, биелэлтийг хангуулах;

5/ тухайн тусгай хамгаалалттай газрын Орчны бүсийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах;

6/ орчны бүсийн зөвлөл болон орон нутгийн төрийн ба төрийн бус байгууллага, аж аухйн нэгж, иргэдийн хамтын ажиллагааг уялдуулах;

7/ тусгай хамгаалалттай газар болон түүний орчны бүсэд байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагааг дэмжих,

8/ Орчны бүсийн санд хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулах журам, төсвийг батлах, зарцуулалтад хяналт тавих;

9/ тусгай хамгаалалттай газрын орчны бүсийн дэд хөтөлбөрийг менежментийн төлөвлөгөөг батлах, түүний хэрэгжилтийн талаар тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны дарга, Засаг дарга болон Орчны бүсийн зөвлөлийн даргын илтгэлийг хэлэлцэн шийдвэр гаргаж, биелэлтийг хангуулах;

10/ Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтыг сайжруулах арга хэмжээний жил бүрийн төсөвт шаардагдах хөрөнгийг баталж зарцуулалтанд хяналт тавих

36 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тусгай хамгаалалттай газар нутгийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг орон нутагт зохион байгуулах;

2/ өөрийн нутаг дэвсгэрийн тодорхой хэсгийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авах, өргөтгөх талаар санал боловсруулж, тухайн шатны ИТХ-д өргөн барих байгууллагад уламжлах;

3/ тусгай хамгаалалттай газрын өөрийн сумын нутаг дэвсгэрт хамрах хэсэгт гарсан түймэр, байгалийн гамшигийн хор уршгийг таслан зогсоох, арилгах арга хэмжээнд хөрөнгө, хүн хүч, техник гаргах, дайчлан ажиллуулах, зохион байгуулах;

3/ орон нутгийн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын менежмент, дэглэмийг боловсруулж, ИТХ-д өргөн барих, хэрэгжилтийг хангах,

4/ орон нутгийн хамгаалалттай газрын менежментийг байгаль орчны чиглэлээр мэргэшиж чадваржсан иргэдийн нөхөрлөл, төрийн бус байгууллагад гэрээгээр хариуцуулан гүйцэтгүүлэх;

5/ хамгаалалтын захиргаа, орчны бүсийн зөвлөлөөс орчны бүсийн менежментийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

6/ сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон журмын дагуу тусгай хамгаалалттай газар нутагт нутаг дэвсгэртээ байгалийн нөөц ашиглах чиглэлээр явуулсан үйл ажиллагаа явуулсны өрлогын тодорхой хэсгийг орчны бүсийн дундын санд төвлөрүүлэх;

7/ тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн менежментийн төлөвлөгөөг сум, дүүргийн ойрын болон дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгжүүлэх;

8/ орчны бүсийн зөвлөлийн үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж, шаардлагатай мэдээллээр хангах, зөвлөлийн гишүүдийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх;

9/ орчны бүсийн зөвлөлийн үйл ажиллагаа тухайн шатны төрийн болон төрийн бус байгууллага, иргэд хоорондын хамтын ажиллагааг уялдуулах

37 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны бүрэн эрх

1. Тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа /цаашид "хамгаалалтын захиргаа" гэх/ нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ үйл ажиллагаа явуулна:

1/ тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх хууль тогтоомж, тухайн газар нутгийн дэглэм, хамгаалалтын менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хангуулах;

2/ эрх бүхий эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтдийн судалгааны үр дүн, тухайн шатны Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын саналыг үндэслэн тухайн газар нутгийн менежментийн төлөвлөгөөг боловсруулж, түүний орчны бүсийн хилийн цэсийг тогтоож, эрх бүхий байгууллагаар батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах; (эргэж харах, хасах)

3/ тусгай хамгаалалттай газар нутгийн ач холбогдол, хамгаалалтын дэглэм, холбогдох хууль тогтоомжийг сурталчлан таниулах, он дарааллын бичиг хөтлөх, мэдээллийн сан бүрдүүлэх;

4/ судалгаа, шинжилгээ хийх сонирхол бүхий иргэд, байгууллагатай гэрээ байгуулан, холбогдох зөвшөөрөл авч, гүйцэтгүүлэн судалгааны үр дүнг хүлээн авах

5/ тухайн газар нутгийн хамгаалалтын дэглэмийн хүрээнд явуулж болох үйл ажиллагаанд зөвшөөрөл олгох, хяналт тавих;

6/ зохих журмын дагуу судалгаа, шинжилгээний зориулалтаар дээж, сорьц авах, амьтны сүргийн бүтэц, удмын санг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх, ойд цэвэрлэгээ, ойжуулалтхийхэд хяналт тавих;

7/ амьтанд зориулан ус задгайлах, хадлан бэлтгэх, өвс тэжээл, хужир, шүү тавих, нөмөр хорго барих болон биотехникийн бусад арга хэмжээг зохих хууль, журмын дагуу гүйцэтгэх;

8/ рашаан, эмчилгээ, сувилгааны зориулалттай эрдэс, байгалийн дагалт баялгийг зохих журмын дагуу ашиглуулах;

9/ зөвшөөрөгдсөн аялал, жуулчлалын зам, чиглэлийг тэмдэгжүүлэх, түр отоглох орон байр барих, тээврийн хэрэгслийн зогсоол гаргах, биеийн тамирын болон нийтийн бусад арга хэмжээ явуулах газар, журмыг тогтоох, эрүүл ахуйн нөхцөлийг нь хангах ажлыг иргэд, иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран тохижуулах;

10/ зөвшөөрөгдсөн бүс дэх барилга байгууламж барих ажлыг батлагдсан зураг, стандарт, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж байгаад хяналт тавих;

11/ байгаль орчинд халгүй хэлбэрээр уул, овоо тахиx, уламжлалт зан үйлийн бусад ёслол үйлдэх ажиллагааг зохицуулах;

12/ зөвшөөрөгдсөн бүсэд байлгаж болох малын төрөл, тоог үндэслэн байгалийн гамшиг, ган зуд тохиолдсон үед, зохих журмын дагуу иргэн, иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад мал бэлчээрлүүлэх ажлыг гэрээний үндсэнд дагуу зохион байгуулах;

13/ тусгай хамгаалалттай газар нутгийн хууль тогтоомж зөрчсөн талаарх мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд өгсөн, зөрчлийг илрүүлэхэд бодитой туслалцаа үзүүлсэн иргэн, албан тушаалтанд зөрчил гаргагчид ногдуулсан шийтгэвэр, нөхөн төлбөрийн орлогын дүнгийн 15%-тай тэнцэх мөнгөн урамшууллыг олгох;

14/ тусгай хамгаалалттай газар нутгийн хууль тогтоомж зөрчсөн иргэн, иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг илрүүлж, байгаль орчин болон байгалийн нөөцөд учруулсан хохирлыг барагдуулсан улсын байцаагч, байгаль хамгаалагчид хууль бусаар бэлтгэж хураалгасан байгалийн баялгийн борлуулалтын орлогын 15%-ийг олгох;

15/ хөнөөлт шавьж, мэрэгчид, түймрээс сэргийлэх, тэдгээртэй тэмцэх аргачлал тогтоох, байгалийн гамшиг, амьтан, ургамлын өвчин, гэнэтийн бусад аюулаас тусгай хамгаалалттай газар нутаг учирсан хор уршгийг арилгах арга хэмжээг зохион байгуулах;

16/ хуульд заасан бусад эрх

17\

38 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн байгаль орчны болон газрын харилцааны газар, усны сав газрын захиргааны бүрэн эрх

1. Аймаг, нийслэлийн байгаль орчны болон газрын харилцаа, усны сав газрын захиргаа нь тусгай хамгаалалттай газар нутгийн харилцааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

1/ Тусгай хамгаалалттай газар нутгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хамтран зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг аймаг, нийслэлийн Засаг дарга, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнах;

2/ аймаг, нийслэлийн орон нутгийн тусгай хамгаалалттай газар болон улсын тусгай хамгаалалттай газар нутгийн мэдээллийн санг бүрдүүлж, газар зохион байгуулалт, газрын кадастр, байгаль орчны төлөв, байдлын тайланг гаргаж, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх.

3/ газар нутгийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтанд авах үндэслэлийг хамтран боловсруулж, зохих шатны Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн хуралд оруулж, шийдвэрлүүлэх;

4/ Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсэд газар, ус ашиглахтай холбоотой хүсэлтэд мэрэгжлийн дүгнэлт гаргаж үр дүнг аймаг, нийслэлийн Засаг дарга, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх [\[BB3\]](#)

39 дүгээр зүйл. Байгаль хамгаалагч, улсын байцаагчийн бүрэн эрх

1. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 28 дугаар зүйл болон Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга нь байгаль орчны хяналтын улсын ахлах байцаагчийн, тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны дарга, хамгаалалт, хяналт шалгалтын ажил хариуцсан мэргэжилтэн болон байгаль хамгаалагчид нь байгаль орчны хяналтын улсын байцаагчийн эрх, үүрэгтэй байна.

2. Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт, хяналт шалгалтын ажлыг хариуцсан мэргэжилтэн, байгаль хамгаалагч, улсын байцаагч нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ энэ хууль болон байгаль орчныг хамгаалах бусад хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх журмын биелэлтэд харьяалал харгалзахгүй хяналт тавьж, илэрсэн зөрчлийг таслан зогсоож, гэм буруутай этгээдэд зохих хариуцлага хүлээлгэх;

2/ хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих зорилгоор аж ахуйн нэгж, байгууллагад нэвтрэн орох, шалгалт хийх, шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт, баримт бичгийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах;

3/ хууль тогтоомж зөрчсөн сэжиг бүхий иргэний бичиг баримтыг шалгах, түр хураах, шаардлагатай гэж үзвэл унаа хөсөгт нь үзлэг хийх, зэвсэг хэрэгсэл, агнасан, түүсэн, бэлтгэсэн зүйлийг хураан авах, түргэн муудаж чанар байдлаа алдах, эсвэл байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эд зүйлийг улсын байцаагчийн акт, зөрчлийн тухай тэмдэглэл үйлдэн хөндлөнгийн хоёр гэрчийг байлцуулан газар дээр нь устгах;

4/ хууль тогтоомж, хамгаалалтын горимыг зөрчиж байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг түр зогсоох, тэдгээрт хугацаатай үүрэг, даалгавар өгч, биелэлтийг хангуулах;

5/ хууль тогтоомж, хамгаалалтын горим зөрчсөн, гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй эдгээдийн үйл ажиллагааг болон зориулалт өөрчилсөн барилга байгууламж барих, ашиглахыг зогсоох арга хэмжээ авах,

6/ хуульд заасны дагуу захиргааны шийтгэл, нөхөн төлбөр ногдуулах, төлбөрийг барагдуулах

7/ хариуцсан нутаг дэвсгэртээ байгалийн баялгийг нөхөн сэргээх, байгалийн гамшиг, гэнэтийн аюул гарсан тохиолдолд хор уршгийг арилгах арга хэмжээ авах ажлыг зохион байгуулах, шаардлагатай бол нийтийн тээврийн хэрэгслээр дараалал харгалзахгүйгээр зорчих, бусад тээврийн хэрэгслийг дайчилж хөлсийг нь төлөх;

8/ хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

(Төрийн хяналт шалгалтын тухай хуулинд уялдуулж өөрчлөлт оруулах)

3. Улсын ахлах байцаагч энэ хуулийн 34 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан эрх үүргийг хэрэгжүүлнэ.

1/ улсын байцаагчийн гаргасан шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд хуульд өөрөөр заагаагүй бол улсын байцаагчийн шийдвэрийг шүүхээр баталгаажуулан албадан гүйцэтгүүлэх, эсхүл тухайн үйлдвэрлэл, үйлчилгээг бүрмөсөн зогсоох тухай санал, дүгнэлтээ холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

2/ ноцтой зөрчил гарсан, хүний амь нас, эрүүл мэнд хохирсон, их хэмжээний хор хохирол учирсан тохиолдолд болон илэрсэн зөрчил нь гэмт хэргийн шинжтэй бол шалгалтын холбогдох баримт бичгийг эрх бүхий байгууллагад шилжүүлж, шийдвэрлүүлэх,

3/ хяналт шалгалтын удирдамжийг батлах, удирдлагаар хангах, зохицуулах, зөвлөн туслах,

4/ улсын байцаагчийн үйл ажиллагаа болон хамгаалалт, хяналт шалгалттай холбогдуулан гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх.

4. Энэ хуулийн 34 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан дарга, мэргэжилтэн, байгаль хамгаалагч нь дээд боловсролтой, экологич, байгаль хамгаалал, байгаль орчны хяналт үнэлгээ, биологич, эрх зүйч, аялал жуучлал, газар зохион байгуулагч, ой, усны чиглэлийн мэргэжилтэй байх ба тэдэнд улсын байцаагчийн эрхийг Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу олгоно.

5. Дархан цаазат болон байгалийн цогцолборт газарт нэг байгаль хамгаалагчийн хариуцан ажиллах талбайн хэмжээг Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт зааснаас 3 дахин бууруулж, тухайн тусгай хамгаалалттай газрын ангилал, хамгаалах дэглэм, онцлог, ачаалал зэргийг харгалзан Засгийн газар тогтооно.

6. Тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах, мэдээлэл өгөх, хяналт тавихад туслах чиг үүрэг бүхий идэвхитэн байгаль хамгаалагч ажиллуулж болно. Идэвхитэн байгаль хамгаалагчийн ажиллах харилцааг тусгай журмаар зохицуулна.

7. Тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах зорилгоор хилийн заставын даргад байгаль орчны хяналтын улсын байцаагчийн бүрэн эрхийг Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу олгож болно. Хилийн заставын дарга нь байгаль орчны хяналтын улсын байцаагчийн бүрэн эрхийг зөвхөн хилийн бүсэд хэрэгжүүлнэ.

40 дүгээр зүйл. Байгаль хамгаалагч, улсын байцаагч бүрэн эрхээ хэрэгжүүлэх баталгаа

1. Засгийн газраас загварыг нь баталсан, албаны болон хувийн дугаар бүхий үнэмлэх, баталгааны тэмдэг, түүнчлэн хяналт шалгалтын хэвлэмэл хуудас, дүрэмт хувцас, ялгах тэмдэг болон бие хамгаалах зэвсэг, техник хэрэгсэл, холбоожуулалт, уналга, тээврийн хэрэгсэл, ажлын байраар хангагдсан байх.

2. Байгаль хамгаалагч, улсын байцаагч нь Төрийн албаны тухай хууль тогтоомжид заасан төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгаа, нэмэгдэл баталгаа, түүнд олгох цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, шагнал урамшил, тэтгэвэр, тэтгэмжээс гадна дор дурдсан нэмэгдэл баталгаагаар хангагдана:

1/ бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй нь холбогдуулан доромжилсон, гүтгэсэн, дарамталсан, амь нас, эрүүл мэндэд нь бодит аюул заналхийлсэн үед, өндөр насны тэтгэвэрт гарснаас хойш 2 жилийн дотор цагдаагийн байгууллагаар аюулгүй байдлаа хангуулах арга хэмжээ авахуулах;

2/ гэнэтийн ослын болон амь насны даатгалд хамрагдах;

3/ төрийн албанд 25 ба түүнээс дээш жил, түүнээс 10 жилийг байгаль хамгаалах албанд ажилласан байгаль хамгаалагч, улсын байцаагчийг өндөр насны тэтгэвэрт гарахад нь 36 сарын цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тусламжийг ажиллаж байгаа байгууллагаас нь төсөвт суулгаж, нэг удаа олгох; (БОХ тухай хуулийн 29 дүгээр зүйлд байгаа шүү)

4/ 5 жил тутамд байгаль хамгаалагчдад 12 сарын цалинтай тэнцэх хэмжээний урамшуулал олгох;

5/ ажиллах орон байраар хангагдах, хөнгөлттэй зээлээр орон сууцны зээл, тусламжид хамрагдах;

41 дүгээр зүйл. Байгаль хамгаалагч, улсын байцаагч галт зэвсэг, бие хамгаалах тусгай хэрэгсэл хэрэглэх

1. Улсын байцаагч, байгаль хамгаалагч хээрийн нөхцөлд хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах үедээ галт зэвсэг, бие хамгаалах тусгай хэрэгсэл биедээ авч явах эрхтэй.

2. Улсын байцаагч, байгаль хамгаалагч хээрийн нөхцөлд хяналт, шалгалт хийх үедээ илэрсэн зөрчил, гадны халдлагыг өөр арга хэрэгслээр таслан зогсоох боломжгүй бол галт зэвсэг хэрэглэхдээ Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан үндэслэлийг мөрдлөгө болгоно.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙНХАМГААЛАЛТЫН МЕНЕЖМЕНТ

42 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын менежментийн зарчим

1. Төр нь байгалийн унаган төрх, экосистем, байгаль орчны тэнцвэрт байдал, байгаль, түүх, соёлын үнэт өвийг үе дамжуулан үлдээж хадгалан хамгаалах зорилго бүхий тусгай хамгаалалттай газар

нутгийн сүлжээг өргөжүүлж түүний [\[U4\]](#) хамгаалалтын менежментийг улс орны болон дэлхийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн хэрэгжүүлнэ.

2. Төр нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын менежментийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.

1/ улсын тусгай хамгаалалттай газар нутаг нь стратегийн үнэт баялаг байх;

2/ тусгай хамгаалалттай газар нутгийг байгаль хамгаалах төрийн бодлогын цөм, байгаль, түүх, соёлын үнэт өвийг хадгалан хамгаалах, экосистемийн тэнцвэрт байдлыг баталгаажуулах гол үндэс болгон хөгжүүлэх;

3/ тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг төрийн бодлого, дэмжлэг, зохицуулалтаар тогтвортой хөгжүүлэх;

4/ тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүс нутгийг ногоон хөгжлийн түшиц, загвар, эко бүс нутаг болгон хөгжүүлэх;

5/ тусгай хамгаалалттай газар нутагт байгалийн нөөцийн ашиглалтыг тухайн газрын экологи-эдийн засгийн үнэлгээ, байгаль орчны даацад нийцсэн байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр явуулах;

6/ тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент нь тухайн газрын байгаль, нийгэм, эдийн засаг болон түүх соёлын судалгаанд үндэслэнэ;

7/ байгалийн нөөц ашигласны төлбөрийн болон байгаль орчинд учирсан нөхөн төлбөрийн орлогын тодорхой хувийг тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын менежментэд зарцуулах;[\[U5\]](#)

8/ тусгай хамгаалалттай газрын менежментийн санхүүжилтийн тогтвортой байдлыг төрөөс баталгаажуулж, бусад талууд болон хувийн хэвшлийн оролцоог дэмжин урамшуулах;

9/ тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний менежментийн үр ашиг, үр нөлөөнд тогтмол хугацаанд мониторинг хийж байнга сайжруулах;

10/ тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөлт хэрэгжүүлэлт нь хамтын менежментийн зарчимд тулгуурласан байх;

~~10/ тусгай хамгаалалттай газар нутаг түүний орчны бүсэд амьдарч буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг тухайн газар нутгийн төлөвлөлт, хамгаалалтын үйл ажиллагаанд өргөнөөр хамруулан олон нийтийн оролцоог хангах;~~

11/ тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ нь орчин үеийн шаардлага, эрэлт хэрэгцээг хангасан бүтэц, удирдлага, зохион байгуулалттай, ил тод байдлыг хангасан сайн засаглалтай байх;

12/ тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг хөгжүүлэхэд гадаад улс орнууд, олон улсын байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх.

43 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөө

1. Улсын тусгай хамгаалалттай газар нутаг бүр менежментийн болон бизнесийн төлөвлөгөөтэй [\[U6\]](#) байна. Орон нутгийн тусгай хамгаалалттай газар менежментийн болон бизнесийн төлөвлөгөөтэй байж болно.
2. Менежментийн болон бизнесийн төлөвлөгөөг боловсруулах аргачлал, журмыг тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлана.
3. Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөнд дараах зүйлийг тусгана:

1/ тухайн тусгай хамгаалалттай газрын алсын хараа,урт хугацааны зорилго, дунд, богино хугацааны зорилтууд түүнд хүрэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлтүүд[\[U7\]](#) ;

2/ тухайн тусгай хамгаалалттай газарнутагт хэрэгжүүлэх үйл ажиллагаа, ажил үйлчилгээний чиглэл, хэлбэр, зохион байгуулалт

3/ тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлж болзошгүй нөлөөлөл, тэдгээрийг арилгах, бууруулах арга хэмжээ;

4/ Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах, үнэлэх, тайлагнах хэлбэр, хугацаа;

4. Бизнесийн төлөвлөгөөнд менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдахад төсөв, зардал, санхүүжилтийн эх үүсвэрийг тооцсон байна[U8] .

5. Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн болон бизнесийн төлөвлөгөөг энэ хуулийн 29 дүгээр зүйлийн 5 (тодруулна) дахь заалтын дагуу тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, орон нутгийн тусгай хамгаалалттай газрын менежментийн болон бизнесийн төлөвлөгөөг тухайн аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэдийн Төлөөллөгчдийн Хурал батлана.

6. Тусгай хамгаалалттай нутгийн менежментийн болон бизнесийн төлөвлөгөөг нь тухайн газар нутагт явуулах үйл ажиллагааны үндэслэл болно.

7. Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан зарим арга хэмжээг холбогдох хуулийн дагуу иргэдийн нөхөрлөл, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж гэрээгээр хэрэгжүүлж болно.

44 дүгээр зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн хамтын менежмент

1. Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг иргэдийн нөхөрлөл, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид урт хугацаагаар бүхэлд нь буюу хэсэгчлэн хариуцуулж болно. Энэ харилцааг Засгийн газрын баталсан журмаар зохицуулна.

2. Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг иргэдийн нөхөрлөл, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид 45 жил хүртлэх хугацаагаар хариуцуулж болох ба гэрээний эхний туршилтын хугацаа 5 жил байх ба менежментийн үр ашиг, үр нөлөөг үндэслэн 10 жил тутам сунгана.

3. Тусгай хамгаалалттай газар нутгийн хамтын менежментийг хэрэгжүүлэх иргэдийн нөхөрлөл, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж нь байгаль орчныг хамгаалах чиглэлээр 5-аас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа эрхэлсэн, мэргэжлийн боловсон хүчинтэй, санхүүгийн хувьд бие даасан байх шаардлагыг хангасан байна.

4. Тусгай хамгаалалттай газар нутагт гэрээгээр газар ашиглан аялал жуулчлалын болон тодорхой ажил үйлчилгээ эрхлэж байгаа иргэн аж ахуйн нэгж, байгууллага нь ашиглаж байгаа газрын орчмын тодорхой газрыг хариуцан хамгаална. Хариуцан хамгаалах газрын хэмжээ, хил зааг, үүрэг, хариуцлагыг газар ашиглах гэрээнд тусгаж, үр дүнг жил бүр дүгнэж ажиллана.

5. Тусгай хамгаалалттай газрын менежментэд талуудын оролцоо хамтын ажиллагааг хангах зорилгоор тухайн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа, аймаг, нийслэл, сум, дүүрэг, байгаль орчны байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн төлөөллөөс бүрдсэн Хамтын менежментийн зөвлөлийг байгуулан ажиллуулж болно. Хамтын менежментийн зөвлөл байгуулах, ажиллуулах журмыг тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлана.

45 ДУГААР ЗҮЙЛ. ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГТ СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ ЯВУУЛАХ

1. Тусгай хамгаалалттай газар нутагт явуулах судалгаа шинжилгээний ажил нь тухайн газар нутгийн менежментийн үйл ажиллагааны үндэслэлийг тодорхойлох, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ.

2. Тусгай хамгаалалттай газар нутагт дотоод, гадаадын эрдэм шинжилгээний байгууллага, судлаач нь судалгаа, шинжилгээний ажлыг батлагдсан журмын дагуу, гэрээний үндсэн дээр явуулж, судалгааны үр дүнгийн тайланг тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаанд хүлээлгэн өгнө.

3. Тусгай хамгаалалттай газар нутагт судалгаа шинжилгээ явуулах журмыг тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага батлана.

ДОЛООДУГААР БҮЛЭГ

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

41 дүгээр зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн төсөв, санхүүжилт

1. Тусгай хамгаалалттай газар нутгийн төсөв нь байгаль орчныг хамгаалах, түүний баялгийн нөөцийг тогтвортой ашиглах, ой хээрийн түймэр, ойн хөнөөлт шавьж, өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэдгээртэй тэмцэх, учирсан хохирлыг арилгах, доройтсон орчныг нөхөн сэргээх, судалгаа, шинжилгээний ажил явуулах, хяналт шалгалт хийх, боловсон хүчнийг давтан бэлтгэх, шаардлагатай техник хэрэгслээр хангах, иргэд олон нийтэд сургалт сурталчилгаа хийх, ажиллагсдын цалин хөлс зэргээс бүрдэнэ.

2. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн санхүүжилт нь дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

1/ улсын болон орон нутгийн төсөв, ~~төсвийн хөрөнгө оруулалт~~;

2/ экосистемийн үйлчилгээний хөлс, тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлэх ажил, үйлчилгээний орлого, аж ахуйн нэгж, байгууллагын биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын зардал;

3/ ~~төргүүл~~, нөхөн төлбөрийн орлого; тусгай хамгаалалттай газар нутагт байгалийн нөөц ашигласны нөхөнтөлбөрийн орлогоос байгаль хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн хувь, хэмжээний доод хязгаарын нийт орлого; тусгай хамгаалалттай газар нутагт газар ашигласны төлбөрийн орлогын 30% хувь; тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль орчин, байгалийн нөөцөд хохирол учруулсны нөхөн төлбөрийн орлого; тусгай хамгаалалттай газар нутагт ус бохирдуулсны нөхөн төлбөрийн орлого; тусгай хамгаалалттай газар нутагт байгаль орчны хууль тогтоомж зөрчигчдөд ногдуулсан захиргааны шийтгэлийн орлого; (ТХГН-т газар түр ашигласны төлбөрийн орлогын 50 хувь гэж оруулах) (БНАТХО-оос байгаль хамгаалах, нөхөн сэргээхдэ зарцуулах хувь хэмжээний тухай хуулийн заалтад үндэслэх)

4/ Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хандив, тусламж;

5\заалт нэмж оруулах

6\ заалт нэмж оруулах

5/хууль тогтоомжоор зөвшөөрсөн болон олон улсын гэрээний дагуух (төсөл хөтөлбөрийн санхүүжилтийн гэж тодруулах) бусад орлого.

6/ Орчны бүсийн сангийн орлогын тодорхой хувь

3. Энэ зүйлийн хоёр дахь хэсгийн 2, 3 дахь заалтад заасан ажил, үйлчилгээ, хураамж, төлбөр, захиргааны шийтгэлийн орлогын хувь хэмжээг тогтоох, орлогыг төвлөрүүлэх, зарцуулах, тайлагнах журмыг Байгаль орчны болон Санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батлана.

42 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн санхүүжилтийн

төвлөрүүлэлт, зарцуулалт, тайлан

1.Энэ хуулийн 41 дүгээр зүйлийн 2.2.2.-2.2.6-д заасан эх үүсвэрийг энэ хуулийн 28 дугаар зүйлийн 9-д заасан дансанд төвлөрүүлнэ. (28.9-д заасан санд төвлөрүүлэх хэрэг байна уу)

2.Тусгай хамгаалалттай нутгийн санхүүжилт нь тусгай хамгаалалттай нутгийн сүлжээ, удирдлага зохион байгуулалтыг бэхжүүлэх, менежмент болон бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх, энэ хуулийн 43 дугаар зүйлд заасан эдийн засгийн хөшүүргийг санхүүжүүлэхэд зарцуулна.

3\ тайлагнах талаар оруулах

43 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах

эдийн засгийн хөшүүрэг

1. Тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль орчныг хамгаалах, түүний нөөцийг тогтвортой ашиглах, нөхөн сэргэх, өсгөн арвижуулах ажилд хүний эрүүл мэнд, байгаль орчинд ээлтэй арга, шинэ санаа, санаачлага нэвтрүүлсэн иргэн, иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг хөнгөлөлттэй зээл олгох, нэмэгдсэн өртгийн болон гаалийн албан татвар, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос хөнгөлөх, чөлөөлөх зэрэг эдийн засгийн хөшүүргээр урамшуулна.

2.Тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг тогтвортой ашиглах, нөхөн сэргээх ажлыг эрхэлдэг иргэн, иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг улсын болон орон нутгийн төсөв, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого, байгаль орчин болон байгалийн нөөцөд учруулсан хохирлын нөхөн төлбөрийн орлогоос санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан иргэн, иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журмыг Байгаль орчин болон Санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлана.

[\[BB9\]](#) НАЙМДУГААР БҮЛЭГ

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГТ ЯВУУЛАХ ҮЙЛ

АЖИЛЛАГАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ, ГАЗАР АШИГЛАЛТ

44 дүгээр зүйл. Тусгай хамгаалалттай газар нутагт явуулах үйл ажиллагаа, ажил үйлчилгээ

1. Тусгай хамгаалалттай газар нутагт аливаа үйл ажиллагаа, ажил үйлчилгээг тухайн газрын хамгаалалтын бүсийн дэглэм, горимд нийцүүлэн зөвшөөрлийн үндсэн дээр явуулна.

2. Тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт явуулах дараах үйл ажиллагаа, ажил үйлчилгээнд зөвшөөрөл олгоно:

1/ шинжлэх ухаан, танин мэдэхүйн болон арилжааны зориулалтаар зураг авах, дүрс бичлэг хийх;

2/ ан агнах, барих;

3/ палеонтологийн болон түүх соёлын дурсгалт зүйлсийн судалгаа шинжилгээ явуулах;

4\ Олон улсын болон гадаадын байгууллага, судлаачид судалгаа шинжилгээний ажил явуулах;

5\ нэн ховор, ховор амьтан, ургамлын судалгаа шинжилгээ явуулах;

6\ энэ хуулийн 12 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 11 дэх заалтад заасан үйл ажиллагаа;

7\ энэ хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3,4 дэх заалтад заасан зориулалтаар газар ашиглах;

8\ дэд бүтцийн байгууламж барих, өөрчлөх, өргөтгөх;

9\ ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх

3. Дараах үйл ажиллагаа, ажил үйлчилгээг тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаатай байгуулсан гэрээний үндсэн дээр хэрэгжүүлнэ:

1/ зөвшөөрөгдсөн бүсэд уламжлалт мал аж ахуй эрхлэх, мал бэлчээрлүүлэх, хадлан бэлтгэх

2/ аялал жуулчлалын тогтоосон замналын дагуу уулын авиралт хийх, усан онгоц, завиар аялах,

3/ судалгаа шинжилгээний ажил хийх

5/ олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах,

6/ улсын тусгай хамгаалалттай газар нутагт агаарын хөлгөөр нам өндөрт нислэг үйлдэх, буулт хийх,

7/ зөвшөөрөгдсөн бүсэд тогтоосон газарт арилжааны зорилгоор худалдаа, үйлчилгээ эрхлэх

8/ зөвшөөрөгдсөн бүсэд тодорхой газрын хамгаалалтыг хариуцан ажиллах

9/ зөвшөөрөгдсөн бүсэд нутгийн иргэд ахуйн зориулалтаар хүнсний ногоо, жимс тарих

4. Дараах үйл ажиллагаа, ажил үйлчилгээг зохих төлбөр, хураамж төлсний үндсэн дээр явуулна:

1/ тогтоосон зам, чиглэлээр аялах

2/ ахуйн зориулалтаар байгалийн дагалт баялаг ашиглах,

3\ ахуйн болон спорт агнуурын зориулалтаар загасчлах

5. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга орон нутгийн тусгай хамгаалалттай газарт явуулах үйл ажиллагаа, ажил үйлчилгээнд тухайн газрын хамгаалалтын горимд нийцүүлэн зөвшөөрөл олгоно.

45 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах

1. Тусгай хамгаалалттай газар нутгийн дэглэм, хамгаалалтын горим, менежментийн төлөвлөгөөг үндэслэн Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад аялал жуулчлал, амралт сувилал, судалгаа шинжилгээ, өвөлжөө, хаваржааны зориулалтаар, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхээргүй болзол, нөхцөл, хугацаа, хэмжээтэйгээр, гэрээний үндсэн дээр газар ашиглуулж болно.

2. Улсын тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглуулахдаа дараах зарчмыг баримтална:

1/ тусгай хамгаалалттай газар дотор газрыг эзэмшүүлж, өмчлүүлэхгүй;

2/ тусгай хамгаалалттай газарт ашиглуулах боломжтой газрын байршил, зориулалт, хэмжээ, чанарыг судалгааны үндсэнд тогтоож, менежментийн төлөвлөгөөнд тусгаж, нийтэд ил тод мэдээлсэн байна;

3/ тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглуулахдаа газрын даацын үнэлгээ, байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний дүгнэлт ба менежментийн төлөвлөгөөг үндэслэнэ;

4/ газар ашиглуулах зөвшөөрөл олгохоос өмнө ашиглуулахаар тогтоосон тухайн газарт аялал жуулчлал, амралт сувилалын болон судалгаа шинжилгээний зориулалтаар барих барилга байгууламжийн ерөнхий хийц загвар, тавигдах шаардлага, стандартыг тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага урьдчилан тодорхойлсон байна.

5/ газар түр ашиглагч нь газрыг тухайн зориулалтаар, байгаль орчинд сөрөг нөлөөгүй, унаган төрхийг алдагдуулахгүйгээр ашиглаж тодорхой хугацааны дараа уг газрыг нөхөн сэргээж, эргүүлэн өгөх үүрэгтэй байна.

6/ газар нь ашиглагчийн давхцалгүй байна;

7/ газар түр ашиглуулахын өмнө тухайн газарт байгуулж болох дэд бүтцийн төрөл, тавигдах техникийн болон стандартын шаардлагыг тодорхойлсон байна;

8/ тусгай хамгаалалттай газарт газар ашиглуулахдаа энэ хуулийн 45 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4, 7 дахь заалтад заасан шаардлага болон сонгон шалгаруулах шалгуурыг хангасан иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж зөвшөөрөл олгоно;

3. Тусгай хамгаалалттай газар нутгийн зөвшөөрөгдсөн бүсэд, дэглэмийн хүрээнд уламжлалт мал аж ахуй эрхлэх, мал бэлчээх, өвөлжөөний хашаа саравч барих, өвөлжөө, хаваржааны болон хадлангийн газар ашиглуулах асуудлыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн төв байгууллагын батласан журмаар зохицуулна.

46 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газарт ашиглуулах газрын байршил, хугацаа, хэмжээ,

1. Тухайн тусгай хамгаалалттай газарт ашиглуулах газрын байршил, хэмжээ, газар ашиглуулах зориулалт, болзолыг улсын тусгай хамгаалалттай газарт байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн тусгай хамгаалалттай газарт аймаг, нийслэл, сум, дүүргийн Итгэдийн төлөөлөгчдийн Хурал тусгай хамгаалалттай газрын менежментийн болон сум дүүргийн газрын менежментийн төлөвлөгөөг үндэслэн тогтооно.

2. Тусгай хамгаалалттай газарт газар ашиглуулах журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

3. Газар түр ашиглах хугацаа 5 жилээс илүүгүй байх бөгөөд дахин сунгах хугацаа 5 жилээс илүүгүй байна.

4. Газар түр ашиглагч нас барсан, нас барсан гэж зарлагдсан, сураггүй болсонд тооцогдсон тохиолдолд уг иргэний өв залгамжлагч, хууль ёсны итгэмжлэгдсэн төлөөлөгч хүсэлт гаргавал газар түр ашиглах эрхийг гэрээний хугацаа дуустал үргэлжлүүлэн түр ашиглаж болно. (газрын тухай хуулиар зохицуулагдана)

47 дугаар зүйл. Газар түр ашиглуулах тухай шийдвэр гаргах

1. Тухайн тусгай хамгаалалттай газарт түр хугацаагаар ашиглуулах боломжтой газрын байршил, зориулалт, хэмжээг судалгааны үндсэн дээр тогтоож менежментийн төлөвлөгөөнд тусган батлуулсан байх ба энэ тухай нийтэд ил тод зарлан мэдээлсэн, сум, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулсан байна.

2. Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага газар түр ашиглах тухай хүсэлтээ хамгаалалтын захиргаанд гаргах ба газрын байршил, хэрэгжүүлэх төслийг хавсаргасан байна.

3. Хамгаалалтын захиргаа газар түр ашиглах тухай хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлт болон төслийг менежментийн төлөвлөгөө, аялал жуулчлал, амралт сувилал, судалгаа шинжилгээний марериаллаг бааз хөгжүүлэх хөтөлбөртэй уялдуулан хянаж, саналаа тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад уламжлана.

4. Тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хүсэлтийг газар ашиглах талаарх бодлого, хөтөлбөр, менежментийн төлөвлөгөө, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг үндэслэн судлаж саналаа ажлын 45 хоногийн дотор Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

7. Хоёр буюу түүнээс дээш этгээд нэг газрыг түр ашиглах тухай хүсэлт гаргавал газар ашиглалтын зориулалт, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, байгаль орчныг хамгаалах талаар авах арга хэмжээний зардал зэргийг харгалзан сонголт хийнэ. Харин аялал, жуулчлал эрхлэх зориулалтаар газар түр ашиглах тухай хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын аялал, жуулчлалын үйл ажиллагаа явуулах үйлчилгээнд холбогдох хууль тогтоомж, стандартад тавигдсан шаардлагыг харгалзан сонголт хийнэ.

5. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тусгай хамгаалалттай газарт газар ашиглах талаарх нэгдсэн бодлого, хөтөлбөр, мэдээллийн сан, газрын кадастрийн бүртгэл, байгаль орчны нарийвчилсан үнэлгээний дүгнэлтэд тулгуурлан Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар түр ашиглуулах тухай Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэр гаргуулна.

6. Тусгай хамгаалалттай газар нутагт газар түр ашиглуулах журмыг Байгаль орчны болон газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлана.

4. Тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хүсэлтийг газар ашиглах талаарх бодлого, хөтөлбөр, менежментийн төлөвлөгөө, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг үндэслэн судлаж саналаа ажлын 45 хоногийн дотор Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

7. Хоёр буюу түүнээс дээш этгээд нэг газрыг түр ашиглах тухай хүсэлт гаргавал газар ашиглалтын зориулалт, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, байгаль орчныг хамгаалах талаар авах арга хэмжээний зардал зэргийг харгалзан сонголт хийнэ. Харин аялал, жуулчлал эрхлэх зориулалтаар газар түр ашиглах тухай хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын аялал, жуулчлалын үйл ажиллагаа явуулах үйлчилгээнд холбогдох хууль тогтоомж, стандартад тавигдсан шаардлагыг харгалзан сонголт хийнэ.

8. Газар түр ашиглуулах тухай шийдвэрт ашиглуулах газрын зориулалт, орших бүс, байршил, зааг, хэмжээ, төлбөрийн хэмжээг тодорхой заана.

9. Газар түр ашиглуулахаас татгалзсан бол байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас үүний шалтгаан, үндэслэлийг тодорхой зааж, хариу өгнө.

10. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь улсын тусгай хэрэгцээний газрын газар зохион байгуулалтын нэгдмэл сангийн тайлан, төлөвлөгөө, мэдээг Газрын

асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дараа жилийн 01 дүгээр сарын 25-ны дотор хүргүүлнэ.

48 дугаар зүйл. Газар түр ашиглах тухай гэрээ

1. Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний гаргасан газар түр ашиглуулах тухай шийдвэрийг үндэслэн тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь тухайн газрын хамгаалалтын захиргаа, сум (дүүргийн) засаг дарга, газар ашиглагч иргэн аж ахуйн нэгж, байгууллагатай хийсэн газар ашиглах тухай гурвалсан гэрээг батлан, газар түр ашиглах тухай гэрчилгээг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад олгоно.

2. Газар түр ашиглуулах гэрчилгээ нь гэрээний хамт хүчин төгөлдөр байна.

3. Газар түр ашиглах тухай гэрээнд дараах зүйлийг тусгана:

1/ газар түр ашиглуулах шийдвэр

2/ газар түр ашиглуулах зориулалт тодорхойлсон төслийн агуулга

3/ газар түр ашиглуулах хугацаа

4/ газрын төлбөрийн хэмжээ, төлөх хугацаа,

5/ гэрээний талуудын эрх, үүрэг, хариуцлага

6/ тухайн газрын унаган төрхийг хадгалах, хамгаалах, нөхөн сэргээх талаар авах арга хэмжээ, тайлагналт, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ;

7/ газар түр ашиглуулах гэрээ, эрхийг цуцлах үндэслэл, цуцлах болсон тохиолдолд газрыг эргүүлж авах нөхцөл, журам, уг газрыг нөхөн сэргээх, засаж тохижуулах, хүлээлгэн өгөх нөхцөл.

8/ бусад зүйл

4. Газар түр ашиглуулах гэрээнд 1:50000 масштабын дагуу үйлдсэн газрын кадастрийн зураг, газар хүлээлгэн өгсөн тухай акт, газрын төлөв байдлын хянан баталагааг хавсаргана.

5. Тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь газрын талаар газар түр ашиглах эрх олгосон, сунгасан, шилжүүлсэн бол эрх бүхий этгээдийн шийдвэр, цуцалсан шийдвэр зэргийг тухай бүр мэдээллийн санд оруулна:

6. Газрын кадастрийн мэдээллийг Кадастрийн тухай хуулиар зохицуулж, мэдээллийг тухай бүр холбогдох байгууллагад хүргүүлнэ.

7. Газар түр ашиглах гэрээний хугацааг сунгахдаа гэрээнд заасан болзол, журмыг биелүүлсэн байдал, хамгаалалтын захиргаа болон сумын захиргаа, холбогдох байгууллагын санал, дүгнэлтийг харгалзан сунгалт хийнэ.

49 дүгээр зүйл. Газар түр ашиглагчийн эрх, үүрэг

1. Тусгай хамгаалалттай газар нутагт газар түр ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага Газрын тухай хуулийн дугаар зүйлд заасан эрх эдэлж, Газрын тухай хуулийн ... дугаар зүйлд заасан үүрэг хүлээхээс гадна дараах үүрэг хүлээнэ:

1/ тухайн газрын унаган төрх, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг өөрийн хөрөнгөөр гүйцэтгэх;

2/ ашиглахаар авсан газартаа тогтоосон замаар орж, гарах;

3/ хууль буюу гэрээнд заасан үйл ажиллагаа явуулахтай холбогдуулан ашиглаж байгаа газрынхаа төлөв байдал, ашиглалтын зориулалтыг өөрчлөхөд хүрвэл холбогдох зураг төслөө байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад танилцуулж зөвшөөрөл авах;

4/ дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэхдээ холбогдох мэргэжлийн байгууллагын шийдвэр, дүгнэлтийг үндэслэх;

5\газрын төлбөр, байгаль нөөц ашигласны болон ус, рашаан ашигласны төлбөрийг газар түр ашиглах шийдвэр гарснаас эхлэн төлөх ;

6/ газар ашиглах эрх дуусгавар болоход ашиглаж байсан газраа нөхөн сэргээн, засаж тохижуулан хамгаалалтын захиргаанд хүлээлгэн өгөх;

50 дугаар зүйл. Газар түр ашиглахтай холбоотой хориглох үйл ажиллагаа

1. Тусгай хамгаалалттай газар нутагт газар түр ашиглуулахдаа дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

1/ тусгай хамгаалалттай газар нутагт гадаад улсын хуулийн этгээд, олон улсын байгууллага, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид газар түр ашиглуулах;

2/ тусгай хамгаалалттай газар нутагт гадаадын ~~100 хувийн~~ хөрөнгө оруулалтаар үйл ажиллагаа явуулах;

3/ ашиглаж байгаа газраа бүхэлд нь буюу зарим хэсгийг бусдад худалдах, барьцаалах, дамжуулан ашиглуулах, зориулалтыг өөрчлөх; (газрын тухай хуультай уялдуулах)

4/ энэ хууль болон тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын горимоор хориглосон, гэрээнд зааснаас өөр буюу хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөх үйл ажиллагаа явуулах;

5/ гэрээнд заасан хариуцан хамгаалах талбайг хаших, ~~д үйл ажиллагаа явуулах~~, барилга байгууламж барих, хэмжээ хэтрүүлэн хаших;

6/ газар дээрх хөрөнгийг үл хөдлөх хөрөнгийн бүртгэлд бүртгүүлэх;

2. Газар түр ашиглагчаас газрыг хуульд заасан үндэслэлээр эргүүлж авах тохиолдолд тусгай хамгаалалттай газар нутгаас түүнд дахин газар олгохгүй.

3. Иргэн, иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага ашиглаж байгаа өвөлжөө, хаваржаа, өтөг бууц, хашаа, орон байрыг гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн газрыг тойруулан хаших, шилжин суурьших;

51 дүгээр зүйл. Газар түр ашиглах эрх дуусгавар болох, цуцлах газрыг чөлөөлөх

1.Тусгай хамгаалалттай газар нутагт газар түр ашиглах эрх дараах тохиолдолд дуусгавар болно:

1/ Энэ хуулийн 45 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 49, 50 дугаар зүйл болон Газрын тухай хуулийн ...дүгээр зүйлд заасан үндэслэлээр;

2/ тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын горим, гэрээнд заасан үүргээ ~~удаа дараа буюу нөцтөй~~ зөрчсөн.

3/ төсөл болон байгаль орчны нарийвчилсан үнэлгээний зориулалт өөрчилсөн, газрын хэмжээ хэтрүүлсэн, газрын төлбөр төлөөгүй, үйл ажиллагаа явуулаагүй 2 жил болсон, бусдад худалдсан, ашиглуулсан, хууль бусаар шилжүүлсэн,

4/ байгаль хамгаалах, нөхөн сэргээх үүргээ хэрэгжүүлээгүй, тайлагнаагүй, байгаль орчинд сөрөг нөлөөлөх үйл ажиллагаа явуулсан,

2. Газар түр ашиглах эрх дуусгавар болоход иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ашиглаж байсан газраа чөлөөлж энэ хуулийн ...дугаар зүйлд заасан гэрээнд өөрөөр заагаагүй бол уг газрыг 90 хоногийн дотор тухайн газар нутгийн хамгаалалтын захиргаанд актаар хүлээлгэн өгнө.

3. Газрыг эргүүлэн хүлээлгэн өгөхөд гарах зардлыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өөрөө хариуцна. Байгаль орчин, газрын хэвлийд учирлуулсан хохирлыг нөхөн төлж, газрыг анх хүлээн авсан байдалд оруулж хүлээлгэн өгнө.

4. Газар түр ашиглах гэрээ цуцлагдсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газраа чөлөөлөх мэдэгдлийг хүргүүлж, чөлөөлөөгүй тохиолдолд Цагдаагийн байгууллага, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай хамтран газрыг албадан чөлөөлнө. Газрыг албадан чөлөөлсөн зардлыг тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас нөхөн төлүүлнэ.

5. Газар түр ашиглах эрх дуусгавар болж, 90 хоногийн дотор газраа чөлөөлөөгүй тохиолдолд (ТХГ-ын захиргааны байцаагч гэж тодорхой болгох) газар дээрх өмчийг акт үйлдэн шүүхээр баталгаажуулж төрийн өмчид шилжүүлнэ.

40 дүгээр зүйл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ

1.Тусгай хамгаалалттай нутагт энэ хуулийн дагуу хэрэгжих төсөл болон орчны бүсэд үйлдвэрлэлийн зориулалтаар ан агнах, анчдын отог байгуулах, аялал жуучлал явуулах, усан сан, далан, хаалт барих, ашигт малтмал хайх, олборлох, авто болон төмөр зам тавих, засварлах зэрэг дэд бүтцийн төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагаа явуулах иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь зохих хууль тогтоомжийн дагуу тухайн төслөөс байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийлгэнэ.

2. Нарийвчилсан үнэлгээний дүгнэлтэд орон нутгийн захиргаа, байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, хамгаалалтын захиргааны болон тусгай хамгаалалттай нутгийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын санал дүгнэлтийг заавал тусгана.

3. Тусгай хамгаалалттай газарт явуулах аливаа үйл ажиллагаа, ажил үйлчилгээнд зөвшөөрөл олгохдоо байгалийн нөөц, даацын судалгаа, байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний дүгнэлт, менежментийн төлөвлөгөөг үндэслэнэ.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИД ТАВИХ ХЯНАЛТ

53 дугаар зүйл. Төрийн хяналт

1. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тусгай хамгаалалттай газрын төрийн захиргааны байгууллага, хамгаалалтын захиргаа, мэргэжлийн хяналтын байгууллагын байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч хяналт тавина.

2. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд зөрчлийн шинж байдал, учруулсан хохирлын хэмжээг харгалзан эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

54 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

1. Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомжийг дараахь байдлаар зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

1/ энэ хуулийн 7, 8, 13, дугаар зүйлд заасан онгон болон хамгаалалтын бүсийн дэглэмийг зөрчсөн иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг нэг сарын Тусгхөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арван тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

2/ энэ хуулийн 9, 15 дугаар зүйлд заасан хязгаарлалтын бүсийн дэглэмийг зөрчсөн иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг нэг сарынхөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арван тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

3/ энэ хуулийн 19 дүгээр зүйл, 22 дугаар зүйлийн 1-т заасан байгалийн нөөц болон дурсгалт газрын дэглэмийг зөрчсөн иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

4/ энэ хуулийн 10, 16, 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 22 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан тусгай хамгаалалттай газар нутагт хориглох үйл ажиллагааг зөрчсөн иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг нэг сарынхөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хорин тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

5/ энэ хуулийн 45 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан газар ашиглахыг хориглосон заалтыг зөрчсөн аж ахуйн нэгж, байгууллагыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг дөч дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

6/ энэ хуулийн 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан газар ашиглахыг хориглосон үйл ажиллагааг зөрчсөн иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гуч дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг нэг сарынхөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг дөч дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

7/ энэ хуулийн 43 дугаар зүйлд заасан байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг тогтвортой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээнд төрөөс төсөвлөн олгосон хөрөнгө болон ажил үйлчилгээний хураамж, байгаль орчин, байгалийн нөөцөд учруулсан хохирлын нөхөн төлбөр, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого, торгууль, захиргааны шийтгэлийн орлого, хандив, тусламжийг өөр зориулалтаар ашигласан албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорьдахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

8/ энэ хуулийн 36, 37, дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлээгүй албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас арван тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

9/ энэ хуулийн 45 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 4, 7 дахь заалтыг зөрчсөн иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав, иргэдийн нөхөрлөлийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох захиргааны шийтгэл ногдуулна.

10\Орчны бүсийн зөвлөл болон сангийн журам зөрчсөн тохиолдолд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэн торгууль ногдуулах арга хэмжээ авах асуудлыг тусгах

11\ТХГН-ийн эд хөрөнгийг эвдсэн этгээдэд хохирлыг арилгуулж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг авах арга хэмжээ

2. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 49 дүгээр зүйл болон Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 5, 6, 9, 10 дугаар зүйлд заасны дагуу тусгай хамгаалалттай газар нутагт хориглосон буюу зөвшөөрөгдөөгүй үйл ажиллагаа явуулсны улмаас байгаль орчин болон байгалийн нөөцөд учруулсан хохирол, ус бохирдуулсны нөхөн төлбөрийг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

55 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

1. Энэхүү хуулийг 20... оны сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.